



МОНГОЛ УЛС
ЁС ЗҮЙН ХОРОО

ТАНИЛЦУУЛГА

МЭДЭЭЛЭЛ

2024 он

Монгол Улсын Ёс зүйн хорооны эрх зүйн байдал: Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны 2023 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Ёс зүйн хорооны үйл ажиллагааны дүрэм”-ийн 1.2.-т зааснаар Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол мэдээллийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах байгууллага мөн.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3. дахь хэсэгт Ёс зүйн хороо нь Төрийн албаны зөвлөлийн гишүүд, орон тооны бус 4, нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4. дэх хэсэгт орон тооны бус 4 гишүүнийг Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо томилж, чөлөөлнө. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 55 дугаар тогтоолоор Ёс зүйн хорооны даргыг ТӨ-ҮА, гишүүдийг ТӨ-ҮИА зэрэг зиндааны албан тушаалд хамааруулсан.

Монгол Улсын Ёс зүйн хорооны бүрэлдэхүүн:



Цэнддаваагийн АМАРТӨГС

Албан тушаал: Ёс зүйн хорооны дарга, Төрийн албаны зөвлөлийн гишүүн
Мэргэжил: Эдийн засаг - менежмент
Зэрэг цол: Бизнесийн удирдлагын магистр, Төрийн удирдлагын магистр
Цахим шуудан: amartugs@ec.gov.mn



Лхагвын ЦЭДЭВСҮРЭН

Албан тушаал: Ёс зүйн хорооны гишүүн, Төрийн албаны зөвлөлийн дарга
Мэргэжил: Эрх зүйч
Зэрэг цол: Хууль зүйн магистр
Цахим шуудан: tsedevsuren@ec.gov.mn



Бадамцоогийн ИДЭРЧУЛУУН

Албан тушаал: Ёс зүйн хорооны гишүүн, Төрийн албаны зөвлөлийн гишүүн
Мэргэжил: Эрх зүйч
Зэрэг цол: Хууль зүйн магистр
Цахим шуудан: iderchuluun@ec.gov.mn



Должингийн БААТАРСАЙХАН

Албан тушаал: Ёс зүйн хорооны гишүүн, Төрийн албаны зөвлөлийн гишүүн
Мэргэжил: Соёл судлаач, Соёлын ажилтан, Эрх зүйч, Төрийн удирдлагын арга зүйч
Зэрэг цол: Удирдахуйн ухааны магистр
Цахим шуудан: baatarsaikhan@ec.gov.mn



Баярын ПҮРЭВДАГВА

Албан тушаал: Ёс зүйн хорооны гишүүн, Төрийн албаны зөвлөлийн гишүүн
Мэргэжил: Эрх зүйч
Зэрэг цол: Удирдахуйн ухааны магистр, Боловсролын докторант
Цахим шуудан: purevdagva@ec.gov.mn



Шайрийн БАТСУХ

Албан тушаал: Ёс зүйн хорооны гишүүн, Монголын сэтгэл зүйчдийн нийгэмлэгийн тэргүүн

Мэргэжил: Сэтгэл судлаач, Төрийн удирдлага

Зэрэг цол: Доктор (Sc.D), профессор

Цахим шуудан: batsukh@ec.gov.mn



Чогдонгийн ЭРДЭНЭЧИМЭГ

Албан тушаал: Ёс зүйн хорооны гишүүн, Удирдлагын Академийн багш

Мэргэжил: Багш

Зэрэг цол: Доктор (Ph.D)

Цахим шуудан: erdenechimeg@ec.gov.mn



Минжүүрийн ЦЭРЭНБАТ

Албан тушаал: Ёс зүйн хорооны гишүүн, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн багш

Мэргэжил: Хүний их эмч, эрх зүйч

Зэрэг цол: Доктор (Ph.D), дэд профессор

Цахим шуудан: tserenbat@ec.gov.mn



Доржсүрэнгийн ДУЛАМСҮРЭН

Албан тушаал: Ёс зүйн хорооны гишүүн, Авлигатай тэмцэх газрын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлтсийн албаны дарга, эрхэлсэн комиссар

Мэргэжил: Эрх зүйч

Зэрэг цол: Хууль зүйн магистр, Удирдлагын Академийн Төрийн удирдлагын докторант

Цахим шуудан: dulamsuren@ec.gov.mn

Чиг үүрэг:

Монгол Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны 2023 оны 09, 10 дугаар тогтоолоор Ёс зүйн хорооны орон тооны бус 4 гишүүнийг томилсноор тус Хороо нь 2024 онд бүрэн бүрэлдэхүүнтэй чиг үүргээ хэрэгжүүлж эхэлсэн.

Ёс зүйн хороо нь 2024 оны үйл ажиллагааны зорилтоо Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан дүрэм, журам, үндэсний хөтөлбөрийг боловсруулан батлуулах, хууль тогтоомжийг сурталчлан таниулах, Ёс зүйн дэд хороог байгуулан ажиллахад удирдлага, арга зүйн дэмжлэг үзүүлж, төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаарх нэгдсэн бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэхэд чиглүүлэн ажиллаж байна.

Соён гэгээрүүлэх сургалт, уулзалт ба дэд хороог чадавхжуулах:

Ёс зүйн хорооноос дэд хороо, эрх бүхий албан тушаалтны чиг үүргээ хэрэгжүүлэх, хууль тогтоомжийг сурталчлан таниулах талаар нэгдмэл ойлголт өгч, арга зүйгээр хангахын зэрэгцээ Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, баримтлах зарчим, харилцаа хандлага, ёс зүйн хариуцлагын төрөл зэрэг сэдвээр сургалт, уулзалтыг зохион байгуулав. Тухайлбал: Ёс зүйн хорооны дарга, гишүүдээр ахлуулсан таван Ажлын хэсэг 2024 оны 3-5 дугаар сард 21 аймаг ажиллаж, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомж, Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангах сургалт, уулзалтад нийт 13,000 гаруй төрийн албан хаагчдыг хамруулсан.

2024 оны 07 дугаар сарын 02-ны өдөр Гадаад хэргийн яамны “Зөвшилцөл” танхимд зохион байгуулсан яам, Засгийн газрын агентлагийн дэргэдэх Ёс зүйн дэд хороодыг чадавхжуулах сургалт, хэлэлцүүлгээс гадна Төрийн албаны зөвлөлийн “7:4:10” арга зүйн вебинар сургалтын хүрээнд зохион байгуулагдсан 3 удаагийн сургалтад 9960, Дэд хороодын захиалгат сургалтад 580, нийт 23,540 төрийн албан хаагч оролцсон.

Ёс зүйн бүртгэл, хяналтын цахим систем:

Төрийн албаны Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо системд суурилсан Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд системийг үүсгэн, туршилтаар ажиллуулж, хөгжүүлэлт хийгдэж байна.

Энэхүү дэд систем нь Төрийн албан хаагчийн ёс зүйн гомдол, мэдээлэл, шийдвэрлэлтийг бүртгэх, дэд хороодын үйл ажиллагаанд хяналт тавих, ёс зүйн төлөв байдал, дүн шинжилгээ хийх, нэгдсэн мэдээ, тайланг гаргах боломжтой болно. Цаашид энэ системийн датад суурилж Ёс зүйн зөрчлийн шалтгаан нөхцөлийг судалж, улмаар урьдчилан сэргийлэх, ёс зүйн зөрчлийг бууруулах бодлого үйл ажиллагаагаа тодорхойлох ёс зүйн дэд бүтэц, менежментийг бий болгох ач холбогдолтой.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, эрх зүйн орчныг бүрдүүлэх:


- Улсын Их Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 27 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр” (2024-2030 он)
- Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор баталсан “Ёс зүйн хорооны үйл ажиллагааны дүрэм”
- Ёс зүйн хорооны 2024 оны 04 дүгээр тогтоолоор “Ажлын албаны орон тооны хязгаарыг батлах тухай”
 - 05 дугаар тогтоолоор “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”
 - 07 дугаар тогтоолоор “Ёс зүйн хорооны хуралдааны дэг батлах тухай”
 - 08 дугаар тогтоолоор “Ажлын албаны үйл ажиллагааны дүрэм батлах тухай”
 - 10 дугаар тогтоолоор “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай”
 - 13 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам”-ыг тус тус батлан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Ёс зүйн хорооны Ажлын албаны бүтцийн бүдүүвч




2024 оны эхний хагас жилийн статистик:

Ёс зүйн хороо нь 21 гомдол, мэдээлэл хүлээн авсан.




Гомдол, мэдээлэлд дурдагдсан албан хаагч:

Төрийн улс төрийн – 5
Төрийн захиргааны – 13
Төрийн тусгай – 1
Төрийн үйлчилгээний – 2



Шилжүүлсэн:



Ёс зүйн дэд хороо нь 308 гомдол, мэдээлэл хүлээн авсан.


Нийслэлийн 172, аймгийн 955, нийт 1127 дэд хороо тайлан, мэдээгээ ирүүлсэн.




Ёс зүйн гомдол, мэдээлэлд дурдагдсан албан хаагч:



Төрийн улс төрийн – 27
Төрийн захиргааны – 119
Төрийн тусгай – 40
Төрийн үйлчилгээний – 103
Бусад – 19




Гомдол, мэдээллийн агуулга:



Гомдол, мэдээлэл бүртгэгдсэн:



Гомдол, мэдээллийн шийдвэрлэлт:



Томилох эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хариуцлага хүлээлгэсэн:



Ёс зүйн хариуцлагыг сайн дураараа хүлээсэн:



Хариуцлага хүлээсэн:

